



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 45

Ховд

“Ховд-Эрч хүч” орон нутгийн өмчит аж ахуйн  
тооцоот үйлдвэрийн газрыг татан буулгах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “ж”, 19 дүгээр зүйлийн 19.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дахь заалтууд, аймгийн ИТХ-ын 2017 оны 3 дугаар хуралдааны 03/02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Ховд-Эрч хүч” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

2.Хот тохижуулах газрын бүтцийг Жаргалант сумын бүтцэд оруулан баталж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-д даалгасугай.

3.“Ховд-Эрч хүч” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын өмч хөрөнгө болох нийт 758594244 төгрөг /долоон зуун тавин найман сая таван зуун ерэн дөрвөн мянга хоёр зуун дөчин дөрөв/-ийн балансын өртөгтэй биет хөрөнгө, хуримтлагдсан элэгдэл нь 355955602 төгрөг /гурван зуун тавин таван сая есөн зуун тавин таван мянга зургаан зуун хоёр/-ийн хөрөнгийг Жаргалант сумын Хот тохижуулах газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

4.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны “Ховд-Эрч хүч” ОНӨААТҮГ байгуулах тухай 39 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 76

Ховд

Дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн орон нутгийн 2018 оны төсвийн төсөл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн саналыг дэмжсүгэй.

2. Төсвийн төсөлд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс гарсан саналыг тусган холбогдох яамдад өргөн мэдүүлж, улсын нэгдсэн төсөвт тусгуулах арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 77

Ховд

Санхүүгийн талаар авах зарим  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, “Төр, орон нутгийн өмчийн төсөвт болон аж ахуйн тооцоот байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч баталгаажуулсан дүн, тайлан тэнцлийн гаргалт, түүнд хийх дүгнэлт, цаашид авах арга хэмжээний тухай” аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Л.Галбадрахын илтгэл, “Төсвийн орон нутгийн өмчийн болон аж ахуйн нэгж байгууллагууд, төсөл, сангуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тэнцлийг хүлээн авсан дүн, цаашид авах арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга М.Отгонхандын илтгэлүүдийг тус тус хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн жилийн эцсийн тайланд орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагч 17, төсөвт байгууллага 134, төрийн сангийн тайлан 17, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж 6, орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж 22, төсөл сангууд 28, нийт 224 байгууллага хамрагджээ.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 2637.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 360,5 сая төгрөгийн материаллаг алдааг аудитын явцад залруулж, 1332,7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага тавьж, 944,2 сая төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагч 17, орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой 28, 85 төсвийн шууд захирагчийн 2016 оны аудитын тайлангаар 13 тэрбум 420.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 7645,4 сая төгрөгийн

материаллаг алдааг аудитын явцад залруулж 4600,6 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг арилгах зөвлөмжийг хүргүүлж, 139,4 сая төгрөгийн 44 акт, 1035.8 сая төгрөгийн 33 албан шаардлага бичсэн байна.

Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 1522 аж ахуйн нэгж тайлагнахаас 91,5 хувь буюу 1393 аж ахуйн нэгж тайлагнасан байна. Үүнд төрийн өмчийн 4, орон нутгийн өмчийн 5, хувьцаат компаний 5, хоршоо 190 байгууллага тус тус бүрэн тушааж хязгаарлагдмал хариуцлагатай 835 компаниас 91,8 хувь буюу 767, 424 нөхөрлөлөөс 92,4 хувь буюу 392, олон нийтийн болон төрийн бус 21 байгууллагаас 66,7 хувь буюу 14 байгууллага тус тус тайлагнасан байна. Дээрх тайлагнасан байгууллагууд 92870,5 сая төгрөгийн борлуулалт хийж 93514,6 сая төгрөгийн зардал гарган 644,1 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг шалган нэгтгэхэд 57 байгууллагын 21 үзүүлэлтээр 54.0 тэрбум төгрөгийн зөрчил илэрснийг засуулах арга хэмжээ авч ажилласныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

1.1. Аудитын байгууллагаас гаргасан зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хангаж, санхүүгийн сахилгыг бүх шатанд сайжруулж, төсвийн үр ашгийг дээшлүүлж ажиллах;

1.2. Орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалтын явцад тавих хяналтыг сайжруулан үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах;

1.3. Орон нутгийн төсөв болон сангуудын хөрөнгийн санхүүжилтээс үүссэн өглөг, авлагын байдалд судалгаа, шинжилгээ хийж, холбогдох байгууллагууд болон хууль хяналтын байгууллагатай хамтран 2017 онд багтаан барагдуулах арга хэмжээ авах;

1.4. Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлтийг хангах байгууллагуудын ажлыг сайжруулж, орлогыг нэр төрлөөр ханган биелүүлэх, төсвийн зарлага санхүүжилтийн хэмнэлтийн бодлогыг тууштай хэрэгжүүлж үр ашгийг дээшлүүлэх, бүх шатанд эцсийн үр дүнд тавих хяналтыг өндөржүүлэн хариуцлага тооцож ажиллах;

1.5. Орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой байгууллагуудын санхүүгийн үр дүнд шинжилгээ хийж, ашигтай ажиллах менежментийн бодлогыг авч хэрэгжүүлэх;

1.6. Өмчийн бүх хэвшлийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгон анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг сайжруулж, санхүүгийн програмаар бүртгэлийг хөтлүүлэн Е тайлан үнэн зөв гаргуулж хэвшүүлэх;

1.7. Санхүүгийн ажилтнуудыг сургаж дадлагажуулах ажлыг эрчимтэй зохион байгуулж чадавхижуулах, олон улсын стандартын бүртгэлийг нэвтрүүлэн тайлагнахад алдаа дутагдалтай ажиллаж байгаа болон аудитын байгууллагын дүгнэлтээр хязгаарлалттай дүгнэлт авсан, төсвийн өрийг өмнөх оноос нэмэгдүүлсэн төсөвт байгууллагуудын төсөв захирагчид болон нягтлан бодогч нарт зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож арга хэмжээ авах;

1.8. Тус тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтийн үр дүнг 2018 оны 2 дугаар сард багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулах.

2. Төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг цахим хэлбэрээр хэрэгжүүлэн шилэн дансны системд байрлуулан иргэд, харилцагч, үйлчлүүлэгч нарыг мэдээллээр хангаж, төсвийн нээлттэй байдлыг сайжруулан хэвшүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагчид, орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн захирлуудад даалгасугай.

3. Аудитын байгууллагын төсөв захирагчдад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтэнд тавих хяналтыг өндөржүүлж аудитын ажлын үр нөлөөг дээшлүүлэн, хувийн хэвшлийн аудитын байгууллагын ажлын чадавхийг сайжруулж ажиллахыг аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор /Л.Галбадрах/-т зөвлөсүгэй.

4. Тус тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэнд/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 48

Ховд

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах  
бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх аймгийн  
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”- ыг хэрэгжүүлэхэд суурилсан эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг аймаг, орон нутгийн бодлого, төлөвлөлтөнд тусган хэрэгжүүлэхэд чиглэгдсэн “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр”- ийг 1 дүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүү, төсвийг жил бүрийн орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөрийн төсөв, төлөвлөгөөнд тусган санхүүжүүлж, хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/- д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 49

Ховд

Хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Малын чанар, үржлийн ажил үйлчилгээг сайжруулах зорилготой “Шилмэл мал” аймгийн дэд хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улс, орон нутгийн төсөв, хөгжлийн бусад сангууд, олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагын санхүүгийн дэмжлэгт хамруулан шийдвэрлэж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-д үүрэг болгосугай.

3. Тус хөтөлбөрийн биелэлтэнд хяналт тавьж, хэрэгжилтийн үр дүнг тооцож, жил бүр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 80

Ховд

Аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр  
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны "Аймгийн шагналын журам батлах тухай" 28 дугаар тогтоолын 1.2.4, 3.1.4 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр шагнасугай. Үүнд:

1. Оралжан Шайзат -Ховд сумын Дунд ус багийн өндөр настан
2. Сыдыхай Кенжихан -Ховд сумын Дунд ус багийн өндөр настан
3. Халым Бахытжол -Ховд сумын Дунд ус багийн иргэн
4. Билал Абайхан -Ховд сумын Баянбулаг багийн малчин
5. Хараа Хуандаг -Ховд сумын Баянбулаг багийн малчин
6. Байтайлах Атышбай -Ховд сумын Баруунсалаа багийн малчин
7. Хадал Даухан -Ховд сумын Цагаанбургас багийн малчин
8. Хумааж Бат-Эрдэнэ -Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч
9. Мандахын Оюунбаяр -Манхан сумын ИТХ-ын Төлөөлөгч
10. Дэмбэрэл Эрдэнэсүрэн -Манхан сумын ИТХ-ын Төлөөлөгч
11. Жамин Ядмаа -Ховд аймгийн харъяат
12. Даваа Түмэннасан -Ховд аймгийн харъяат
13. Шогейбай Анархан -Буянт сумын иргэн
14. Тумаг Цэцэгмаа - Ховд аймаг Сум дундын шүүхийн ерөнхий шүүгч
- 15.Бэгзжав Ганзориг -Дөргөний УЦС-ын Ашиглалтын албаны дарга

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 81

Ховд

Ховд аймгийн “Хүндэт иргэн” шагналаар  
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2.2, 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Галдан бошгот хааны хөшөө, аймгийн сүлд, далбааны загвар, “Дэлхийн соёлын биет бус өв Монгол туульсад” зориулсан “Хан алтайн дуулал” хөшөө, цогцолборыг бүтээн байгуулсан, аймгийн олон үндэстэн ястны урлаг, соёлын бүтээлийг хадгалан хамгаалах, нийтэд сурталчилан таниулах, уран бүтээлчдийг сурган хөгжүүлэхэд онцгой гавъяа байгуулсан Монгол улсын Төрийн соёрхолт, Соёлын гавъяат зүтгэлтэн, уран барималч Лхамсүрэнгийн Ганхуягийг Ховд аймгийн “Хүндэт иргэн” шагналаар шагнасугай.

2. Ховд аймгийн “Хүндэт иргэн” шагналаар шагнагдагдсан алдартны хөдөлмөр бүтээл, гавъяаг нийтэд сурталчилж, энгэрийн тэмдэг, үнэмлэх, дагалдах шагналыг гардуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Г.Пүрэвганди/, аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/ нарт зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 82

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Гавъяат тээвэрчин” цолоор

1. Сулуейман Далелхан -Үенч сумын Хөх үзүүр багийн өндөр настан

“Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор

2. Сурмаа Чойням -Дарви сумын харъяат иргэн  
3. Төгс Цэвээн -Жаргалант сумын Хайрхан багийн иргэн  
4. Даржаа Очир -Жаргалант сумын Наран багийн өндөр настан

“Цэргийн гавъяаны улаан тугийн одон”-гоор

5. Пэрэнлэй Тулга -Жаргалант сумын Наран багийн өндөр настан

“Алтан гадас одон”-оор

6. Эрэн Даваасүрэн -Жаргалант сумын Наран багийн өндөр настан  
7. Балт Зулхүү -Жаргалант сумын Жаргалан багийн өндөр настан  
8. Магсар Төмөрбалт -Жаргалант сумын Буянт багийн иргэн  
9. Бүлхнээ Бороо -Жаргалант сумын Буянт багийн иргэн  
10. Цэдэндамба Баярсайхан -Жаргалант сумын Буянт багийн иргэн

- |                              |   |
|------------------------------|---|
| 11. Биръяа Гомбожав          | -Барилгын "ББМЗЗТ" ХХК-д хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер |
| 12. Ичинхорлоо Загдаа        | -БОЭТ-ийн Хүлээн авах яаралтай тусламжийн тасгийн жолооч              |
| 13. Цэдэв Норжмаа            | -Жаргалант сумын Наран багийн иргэн                                   |
| 14. Юндэн Должинсүрэн        | -Жаргалант сумын Жаргалан багийн иргэн                                |
| 15. Лувсандагва Чулуунбаатар | -Жаргалант сумын Наран багийн иргэн                                   |
| 16. Цэдэвсүрэн Төмөрбаатар   | -Жаргалант сумын Наран багийн иргэн                                   |
| 17. Лувсанжамж Батцэцэг      | -Үенч сумын Хөх үзүүр багийн иргэн                                    |
| 18. Дарьжав Оюунбилэг        | -УТЭХ-ийн ЖТИ хоршооны гишүүн   |
| 19. Дамба Сайнбилэг          | -Жаргалант сумын Наран багийн өндөр настан                            |
| 20. Галсаннамжил Мөнхбаатар  | -ХЭАА нягтлан бодогч  |
| 21. Батсүх Мөнхбаатар        | -ХХААГ МЭОАЦ-ийн лабораторийн эрхлэгч                                 |
| 22. Цэрэндорлиг Буянтогтох   | -ХХААГ хүнсний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний албаны дарга         |
| 23. Шагдармаа Оюунжаргал     | -ХАА, Газар тариалан эрхлэгч  |
| 24. Равдан Янжмаа            | -Аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн          |
| 25. Жамсран Жаргалзаяа       | -Ус цаг уур, орчны шинжилгээний газрын өртөөний дарга                 |
| 26. Хандаа Хишгээ            | -Ус цаг уур, орчны шинжилгээний газрын өртөөний техникч               |
| 27. Отгонхишиг Цагаанмандал  | -Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн багш                         |
| 28. Цэнджав Оюундулам        | -БОЭТ-ийн халдвартын тасгийн ээлжийн сувилагч                         |
|                              | "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар                                       |
| 29. Чойдор Цэвээннамжил      | -Манхан Эрүүл мэндийн төвийн ээлжийн сувилагч                         |
| 30. Даваахүү Цэнд-Аюуш       | -Ахмад эмэгтэйчүүдийн Сүүн сэтгэл холбооны гишүүн                     |
| 31. Хандаа Батчулуун         | - Жаргалант сумын Хайрхан багийн өндөр настан                         |

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 83

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн “к”, 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Мянган угалзат” ОНӨААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагааны орлогын доод хязгаарыг 210140,0 төгрөг /хоёр зуун арван сая нэг зуун дөчин мянга/, зарлагын дээд хязгаарыг 206789,0 төгрөг /хоёр зуун зургаан сая долоон зуун наян есөн мянга/, цалингийн санг 92879,9 төгрөг /ерөн хоёр сая найман зуун далан есөн мянга есөн зуу/, ашгийг 3351,0 төгрөг /гурван сая гурван зуун тавин нэгэн мянга/ байхаар тус тус баталсугай.

2. “Мянган угалзат” ОНӨААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагааны санхүүгийн төлөвлөгөөг зохих журмын дагуу салбар нэгж, зардлын ангилал бүрээр хуваарилан баталж мөрдүүлэн, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ц.Бат-Эрдэнэ/-д, байгууллагын орлогыг нэмэгдүүлэн хөрөнгө, санхүүгийн үр ашгийг дээшлүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал /Н.Ганбат/-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 84

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн "к", 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Ховд суварга" ОНӨААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагааны орлогын доод хязгаарыг 82600,0 төгрөг /наян хоёр сая зургаан зуун мянга/, зарлагын дээд хязгаарыг 82600,0 төгрөг /наян хоёр сая зургаан зуун мянга/, цалингийн санг 43700,0 төгрөг /дөчин гурван сая долоон зуун мянга/, ашиг /алдагдал/-ийг 0,0 төгрөг /тэг/ байхаар тус тус баталсугай.

2. "Ховд суварга" ОНӨААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагааны санхүүгийн төлөвлөгөөг зохих журмын дагуу салбар нэгж, зардлын ангилал бүрээр хуваарилан баталж мөрдүүлэн, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Л.Баярсайхан/-д, байгууллагын орлогыг нэмэгдүүлэн хөрөнгө, санхүүгийн үр ашгийг дээшлүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал /Л.Хатанбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 85

Ховд

Хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.5 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй 550000000 төгрөг /Таван зуун тавин сая/-ийн балансын үнэтэй, 36666666.72 төгрөг /Гучин зургаан сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг далан хоёр мөнгө/-ийн хуримтлагдсан элэгдэлтэй Ахуйн үйлчилгээний барилгыг Ховд аймгийн Онцгой байдлын газрын дэргэдэх Зэрэг сумын гал унтраах ангид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хөрөнгийг зохих журмын дагуу Төрийн өмчид бүртгэснээр хүлээлцүүлэн бүртгэлээс хасаж өөрчлөлт хийхийг Зэрэг сумын Засаг дарга, тус тогтоолыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн хөрөнгийг зохих журмын дагуу төрийн өмчийн бүртгэлд бүртгүүлэхийг Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга /Б.Алтанбадралт/ нарт тус, тус үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 86

Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24, 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.5 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн аймгийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэх нийт 16 нэр төрлийн 43 ширхэг 30.0 сая төгрөг /Гучин сая /-ийн үнэтэй хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолоор баталсан хөрөнгийг байгууллагын балансад бүртгэж ашиглалтыг хариуцаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Ганболд/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 87

Ховд

Журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25, 29, 30, 31, 75, 77, 80 дугаар зүйл, Төрийн өмчийн Бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1."Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан журмыг 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолыг 2017 оны 09 дүгээр сарын 28 -ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 88

Ховд

Хяналтын зөвлөлийн журмын  
шинэчилсэн найруулгыг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67, 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, Төрийн өмчийн хорооны 2007 оны 444 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын “Хяналтын зөвлөлийн ажиллах нийтлэг журам”-ын шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, батлагдсан журмыг 2017 оны 09 дүгээр сарын 28-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж ажиллахыг аймгийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хяналтын зөвлөлд үүрэг болгосугай.

3. Тус тогтоолын хэрэгжилтийг хангуулан, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

4. Тус журам батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 140 дүгээр тогтоолыг 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 89

Ховд

Агуулах бэлтгэх, түүнд хөрөнгө хадгалах  
журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67, 68, 77 дугаар зүйл, Сангийн сайдын 2000 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Агуулах бэлтгэх, түүнд хөрөнгө хадгалах журам”-ын шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталж, 2017 оны 09 дүгээр сарын 28-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

2.Тус журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн захирал, төсвийн захирагчдад даалгаж биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт зөвлөж, Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Тус журам батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 34 дүгээр тогтоолыг 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 90

Ховд

Г Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслэх  
журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслэх журмын шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталж 2017 оны 09 дүгээр сарын 28-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Тус журмын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлж ажиллахыг орон нутгийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төсөвт байгууллагуудын захирал, дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 166, 167 дугаар тогтоолуудыг 2017 оны 09 дүгээр сарын 28-ний өдрөөс тус, тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Тус тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 91

Ховд

Түрээсийн гэрээний загвар баталж,  
төлбөрийн доод үнэ тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28, 77, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 90 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын саналыг тус, тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварыг 1 дүгээр хавсралтаар, хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод үнийг 2 дугаар хавсралтаар тус, тус баталж 2017 оны 09 дүгээр сарын 28-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Тус тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлж ажиллахыг орон нутгийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төсөвт байгууллагуудын захирал, дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Тус тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 167 дугаар тогтоолыг 2017 оны 09 дүгээр сарын 28-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 92

Ховд

Гэрээний загварын шинэчилсэн  
найруулгыг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26, 27, 77, 80 дугаар зүйл, Төрийн өмчийн хорооны 2009 оны 408 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Орон нутгийн өмчийн хуулийн этгээдтэй байгуулах “орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний загвар”-ыг 1 дүгээр, “өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх журам”-ыг 2 дугаар, гэрээний биелэлт дүгнэх үзүүлэлтийг 3 дугаар хавсралтаар тус, тус баталсугай.

2. Тус журмын дагуу өмч эзэмшүүлэх гэрээг байгуулж, биелэлтийг дүгнүүлж ажиллахыг орон нутгийн өмч /өмчийн оролцоотой/ аж ахуйн нэгж, төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчийн байгууллагуудтай өмч эзэмшүүлэх гэрээг байгуулж, биелэлтийг дүгнэж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

4. Тус тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний загвар” батлах тухай 36, 2014 оны “Өмч эзэмшүүлэх гэрээний биелэлт дүгнэх үзүүлэлт” батлах тухай 142 дугаар тогтоолуудыг 2017 оны 09 дүгээр сарын 28-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 93

Ховд

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25, 29, 30, 31, 77, 80 дугаар зүйл, Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 тоот тогтоол, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй эд хөрөнгийг худалдах дуудлагын худалдааг зохион байгуулах журмыг 1 дүгээр хавсралтаар, дуудлага худалдааны зарын маягтыг 2 дугаар хавсралтаар, дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийн маягтыг 3 дугаар хавсралтаар, дуудлагын худалдааны тэмдэглэлийн маягтыг 4 дүгээр хавсралтаар, худалдах, худалдан авах гэрээний загварын маягтыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан тогтоолыг 2017 оны 09 дүгээр сарын 28 -ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны "Хөрөнгийн дуудлагын худалдаа зохион байгуулах журам батлах тухай" 32 дугаар тогтоолыг 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4. Аймгийн өмчийн санд төвлөрүүлсэн төсвийн орлогын 10 хүртэлх хувийг орон нутгийн өмчийн газрын дуудлагын худалдааг зохион байгуулах, өмч хөрөнгөнд хяналт



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 94

Ховд

Журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77, 80 дугаар зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчит байгууллагуудын "Орон нутгийн өмчит этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам"-ын шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталж, 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Батлагдсан журмын биелэлтийг хангаж ажиллахыг орон нутгийн өмчит байгууллагууд, аймаг, сумын Засаг дарга, төсвийн бүх шатны захирагчид, бүртгэл санхүүгийн ажилтнуудад, хэрэгжилтийг хангаж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д тус, тус үүрэг болгосугай.

3. Тус журам батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 31 дүгээр тогтоолыг 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 95

Ховд

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Соёлын биет бус өвийг сурталчлан таниулах, хадгалан хамгаалахад чиглэсэн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдад мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг хангаж, биелэлтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 96

Ховд

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Түүх соёлын өв, дурсгалыг хадгалах, байгалийн эрсдэлт хүчин зүйл, хууль бус ажиллагаанаас хамгаалах зорилготой” Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг хангаж, биелэлтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 97

Ховд

Аймгийн Сонгуулийн хорооны  
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай


Монгол улсын Сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалт, аймгийн Сонгуулийн хорооны 2017 оны 56 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох сонгуулийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах аймгийн Сонгуулийн хороог байгуулсан 2016 оны 88 дугаар тогтоолын хавсралтаар баталсан аймгийн сонгуулийн хорооны гишүүн У.Цэрэнтогтох Эрдэнэбүрэн сумын Засаг даргаар томилогдсон, аймгийн Зоонозын өвчин судлалын албаны дарга А.Оюунчимэг өндөр настны тэтгэвэрт гарч ажлаас чөлөөлөгдсөн тул тус сонгуулийн хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

2. Аймгийн сонгуулийн хорооны чөлөөлөгдсөн гишүүдийн оронд аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны дарга А.Энхзаяа, аймгийн номын сангийн дарга Т.Эрдэнэтуяа нарыг 2017 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн тус тус томилсугай.

3. Аймгийн Сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг нийтэд мэдээлэн, сурталчилж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 98

Ховд

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.7, 20.1.9, 20.1.14 дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгчдийн хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх, туршлага судлах, ур чадварыг хөгжүүлэх, хууль эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд чиглэсэн “Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 99

Ховд

Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр  
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Аймгийн шагналын журам батлах тухай” 28 дугаар тогтоолын 1.2.4, 3.1.4 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд:

- |                          |   |
|--------------------------|---|
| 1. Л.Надмид              | -Ховд сумын Баруун салаа багийн малчин  |
| 2. Б.Атшыбай             | - Ховд сумын Баруун салаа багийн малчин |
| 3. Халидолда Хуандых     | -Ховд сумын Цаг уурын өртөөний техникч  |
| 4. Цэдэндорж Наранцацрал | -УБ хот дахь 4-р цахилгаан станц        |
| 5. Бөхөө Цагаач          | -Ховд Их сургуулийн багш                |
| 6. З.Лхагвасүрэн         | -Бие биелгээний холбооны тэргүүн        |
| 7. Д.Буянхишиг           | -Соёл урлагийн салбарын өндөр настан    |
| 8. Ж.Должин              | -Ховд аймгийн БТСГ-т үйлчлэгч           |
| 9. Дамдин Дагийсүрэн     | -Ховд аймгийн БТСГ-т үйлчлэгч           |
| 10. Риймэд Бүдийдагий    | -Ховд аймгийн мал аж ахуй салбар        |
| 11. Бадарч Халтар        | -Ховд аймгийн мал аж ахуй салбар        |
| 12. Бадарч Нямаа         | -Мөнххайрхан сумын Ахмадын холбоо       |



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 99

Ховд

Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр  
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Аймгийн шагналын журам батлах тухай” 28 дугаар тогтоолын 1.2.4, 3.1.4 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд:

- |                          |   |
|--------------------------|---|
| 1. Л.Надмид              | -Ховд сумын Баруун салаа багийн малчин  |
| 2. Б.Атшыбай             | - Ховд сумын Баруун салаа багийн малчин |
| 3. Халидолда Хуандых     | -Ховд сумын Цаг уурын өртөөний техникч  |
| 4. Цэдэндорж Наранцацрал | -УБ хот дахь 4-р цахилгаан станц        |
| 5. Бөхөө Цагаач          | -Ховд Их сургуулийн багш                |
| 6. З.Лхагвасүрэн         | -Бие биелгээний холбооны тэргүүн        |
| 7. Д.Буянхишиг           | -Соёл урлагийн салбарын өндөр настан    |
| 8. Ж.Должин              | -Ховд аймгийн БТСГ-т үйлчлэгч           |
| 9. Дамдин Дагийсүрэн     | -Ховд аймгийн БТСГ-т үйлчлэгч           |
| 10. Риймэд Бүдийдагий    | -Ховд аймгийн мал аж ахуй салбар        |
| 11. Бадарч Халтар        | -Ховд аймгийн мал аж ахуй салбар        |
| 12. Бадарч Нямаа         | -Мөнххайрхан сумын Ахмадын холбоо       |



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 100

Ховд

Зөвшөөрөл олгох тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Ховд аймгийн нутаг дэвсгэрт Шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Жаргалант сумын Магсаржав багийн нутаг дэвсгэрт байрлаж үйл ажиллагаа явуулах “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ховд цуглаан”-ны үйл ажиллагааг 2017 оны 09 дүгээр сарын 28-ний өдрөөс 1 жил /нэг/-ийн хугацаатай зөвшөөрсүгэй.

2. Аймгийн Жаргалант сумын Магсаржав багийн нутаг дэвсгэрт байрлаж үйл ажиллагаа явуулж байсан “Есүс Христийн Хожмын үеийн Гэгээнтнүүдийн Сүм”-ийн үйл ажиллагааны зөвшөөрөл олгосон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 1999 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 20 дугаар тогтоолыг 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

3. Үйл ажиллагаандаа “Ховд аймгийн нутаг дэвсгэрт сүм хийд байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ыг удирдлага болгон ажиллахыг “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ховд цуглаан” Христийн чуулганы ахлагч /Д.Ганзоригт/-т зөвлөсүгэй.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 101

Ховд

Журмын шинэчилсэн найруулгыг  
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 удгаар зүйлийн 20.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67, 77 дугаар заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Орон нутгийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталж 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Тус журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-т, хэрэгжилтийг хангуулан биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын дарга /Г.Пүрэвганди/-д тус, тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 33 дугаар тогтоолыг 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ